



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 15 өдөр

Дугаар

А/14

Сүмбэр сум

Өмч хамгаалах зөвлөлийг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

КОМИССЫН ДАРГА:

Э.Цэлмэгбаяр

ГИШҮҮН:

Л.Эрдэнэчимэг

ГИШҮҮН:

Т.Отгонтамир

2. Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга /Э.Цэлмэгбаяр/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбоотойгоор байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Өмч хамгаалах зөвлөл томилох тухай” А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.АЛТАНЦЭЦЭГ

